



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/393

Зуунмод

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлаж, хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 7.11, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчний, эрсдэл бүхий Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудаас гоц халдварт өвчний шинжилгээний бичиггүй мал, амьтан хүлээн авахыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хориглосугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнөөр ирсэн малд нэг бүрчлэн үзлэг хийх, сумын мал эмнэлгийн тасаг, нэгжийн эмчийг мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Б.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдаж буй Мөнгөнморьт, Эрдэнэ, Архуст, Баян, Баянжаргалан, Баяндэлгэр, Зуунмод сумдын Засаг дарга нарт дархлаажуулалтын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 10-ны дотор технологийн дагуу түргэн шуурхай гүйцэтгэхэд онцгой анхаарч, отор нүүдлээр дамжин өнгөрч буй малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулахыг дээрх сумын Засаг дарга, мал эмнэлгийн тасаг-үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

4121011123